



ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ГЭМ БУРУУГУЙД ТООЦОГДСОН ЭТГЭЭДИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙГ ЗӨВХӨН АЖИЛ ОЛГОГЧ ТӨЛНӨ

САНАМЖ: Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: 001/ХТ2024/0004

Шүүхийн шийдвэрийн огноо: 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр

Шийдвэрийн төлөв: Анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалд өөрчлөлт оруулж, үлдэх хэсгийг хэвээр үлдээж, нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэв.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Нэхэмжлэгч компанийн захирлыг 2010 оны 05 дугаар сараас эхлэн бусдыг залилсан, итгэмжлэл хуурамчаар үйлдсэн гэмт хэрэгт буруутган шалгаж, хэрэг шийдэгдэх хугацаанд нийт 274 хоног цагдан хорьсон байна. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс² нэхэмжлэгч компанийн захирлын үйлдлийг гэмт хэргийн шинжгүй гэж үзэн хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ. Нэхэмжлэгчээс эрүүгийн хэрэг хэрхэн шийдвэрлэгдэх нь тодорхойгүй байсны улмаас 2011 оны 01 дүгээр сараас 2014 оны 09 сар дуустал хугацааны цалинд оногдох шимтгэлийг даатгуулагчийн 01 код буюу 21 хувиар (ажил олгогч, ажилтан) тооцож тайланд тусгасан байна. Улмаар тус компанийн захирлыг цагаатгаж цагдан хоригдсон хугацааны нөхөн төлбөрийг Засгийн газрын нөөц сангаас гаргасан байна.

Нэхэмжлэгчээс дээрх үйл баримтад тулгуурлан С дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдуулж “Хөрөнгө оруулагч³ нарын 2011 оны 01 дүгээр сараас 2015 оны 08 дугаар сарыг дуустал хугацааны цалинд оногдуулсан шимтгэлийг даатгуулагчийн 32 код буюу 8 хувиар тооцон тайланг залруулж бүртгэхийг даалгах” шаардлага бүхий нэхэмжлэл гаргажээ.

ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүхээс:** Шүүх хууль ёсны итгэлийг хамгаалах зарчмын үүднээс тухайн хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага хууль бусаар ажлаас зайлуулагдан

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: https://shuukh.mn/single_case/3207?daterange=2024/01/01%20-%202024/03/20%20&id=3&court_cat=3&bb=1.

² Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн 610 дугаар тогтоолоор хэргийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн.

³ Тус хуулийн этгээдийн захирлыг оролцуулан нийт 5 хөрөнгө оруулагчтай.



мөрдөгдсөн, эсхүл хилс хэргээр хорих ял эдэлсний улмаас энэ нь компанийн үйл ажиллагаанд нөлөөлсөн эсэх, хувьцаа эзэмшигч нарт хамаарах даатгуулагчийн үүрэгт нь дээрх нөхцөл байдал нөлөөлсөн эсэхийг тодруулах учиртай бөгөөд нийт 274 хоног цагдан хоригдсон талаар эрүүгийн анхан шатны шүүхийн шийдвэрт дурдсан, энэхүү хугацааны тооцоололд талуудын хэн аль нь маргаагүй. Иймд нэхэмжлэгчийн нэхэмжлэлдээ дурдсан хугацаанаас нийт 274 хоног цагдан хоригдсон хугацааны цалинд оногдуулсан шимтгэлийг даатгуулагчийн 32 код буюу 8 хувиар тооцон тайланг залруулж бүртгэхийг зүйтэй гэж үзэн нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэсэн байна.

2. **Давж заалдах шатны шүүхээс:** Анхан шатны шүүхээс хуулийг зөв тайлбарлан хэрэглэсэн, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил гаргаагүй байх тул анхан шатны шүүхийн шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн давж заалдах гомдлыг хангахгүй орхин шийдвэрлэжээ.
3. **Нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын үндэслэл:** Хэргийн гэм буруу эцэслэн шийдвэрлэгдээгүй, тайланг хуулийн хугацаанд нь баталгаажуулах үүрэгтэй тул тус компани 2011 оны 01 дүгээр сараас 2014 оны 07 дугаар сар дуустал хугацааны цалингийн шимтгэлийг даатгуулагчийн 01 код буюу 21 хувиар (ажил олгогч, ажилтан) тооцож тайланд тусгасан гэх үндэслэлээр хяналтын шатны шүүхэд гомдол гаргажээ.
4. **Хяналтын шатны шүүхээс:** Нэхэмжлэгч компанийн захирал “бусдыг хуурч мэхлэх аргаар залилсан, нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн” гэмт хэрэгт буруутгагдан шалгагдаж, гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон нь хэрэгт авагдсан баримтаар тогтоогдсон байна. (9)⁴
5. Энэхүү хэргийн хувьд хяналтын шатны шүүхээс шийдвэрлэж, хариу өгөх шаардлагатай хууль зүйн асуудал нь нэхэмжлэгчийн гүйцэтгэх удирдлагыг эрүүгийн журмаар шалгагдаж, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан нийт хугацаанд түүний өмнө авч байсан цалинд оногдуулсан шимтгэлийг даатгуулагчийн 32 код буюу 8 хувиар тооцох үндэслэлтэй эсэх эсхүл зөвхөн цагдан хоригдсон хугацаанд цалинд оногдуулсан шимтгэлийг даатгуулагчийн 32 код буюу 8 хувиар тооцох эсэх тухай байна. (12)
6. Ямар тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох, уг хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийг ямар, хувь хэмжээгээр хэрхэн төлөхтэй холбоотой харилцааг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн

⁴ “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.



- тухай хууль /1994 он/-ийн 3 дугаар зүйлийн 3.3⁵, 3.3.4⁶ болон 3.7⁷ дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Засгийн газрын 1994 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 212 дугаар тогтоолоор батлагдсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам”-аар зохицуулжээ. (14)
7. Журмын 2-ын 8-д зааснаар даатгуулагчийн **уг хугацаанд ногдох шимтгэлийг тухайн даатгуулагчийн хилсээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь нэг удаа нийгмийн даатгалын санд төлөхөөр тусгасан байна.** (15)
8. Харин анхан шатны шүүх “... нэхэмжлэгч компанийн захирал нь **нийт 274 хоног цагдан хоригдсон, ... дээрх хугацаанд хамааралтай хэсгээр нь нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгох нь зөв**” гэж, давж заалдах шатны шүүх “... цагдан хоригдохоос бусад хуульд заасан таслан сэргийлэх арга хэмжээ нь хүнийг ажил хөдөлмөр эрхлэх болон бусад эрхийг хязгаарладаггүй ба нэхэмжлэгч компанийн захирал нь эрүүгийн журмаар эрх бүхий байгууллагад шалгагдсан нь дээрх зохицуулалтад хамаарахгүй” гэж зөвхөн цагдан хоригдсон хугацаанд хамаарах хэсгийг салган тооцож, дээрх журмын үйлчлэлд хамааруулсан нь үндэслэлгүй, хууль, журмын **“хууль бусаар ... мөрдөгдсөн” гэж заасныг буруу тайлбарлан хэрэглэжээ.** (17)
9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.9⁹ дахь хэсэгт зааснаар дээрх хууль, журамд заасан **“хууль бусаар ... мөрдөгдсөн” гэдгийг эрүүгийн гэмт хэрэгт** (гэмт хэргийн шинжгүй үндэслэлээр хэрэгсэхгүй болсон) яллагдагчаар татаж, мөрдөн шалгах ажиллагаа явагдсан, **уг хугацаандаа цагдан хоригдсон нөхцөл байдал зэргийг хамааруулж ойлгох бөгөөд энэ тохиолдолд даатгуулагчийн уг хугацаанд ногдох шимтгэлийг ажил олгогчийн**

⁵ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994)-ийн 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэг, “Төр, аж ахуйн нэгж, байгууллагаас дараах хугацааны шимтгэлийг тэтгэврийн болон тэтгэмжийн даатгалын санд төлсөн тохиолдолд эдгээр хугацааг шимтгэл төлсөн хугацаанд оруулан тооцно”.

⁶ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994)-ийн 3 дугаар зүйлийн 3.3.4 дахь заалт, “хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн хугацаа”.

⁷ Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль (1994)-ийн 3 дугаар зүйлийн 3.7 дахь хэсэг, “Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хугацааны шимтгэл төлөх журмыг Засгийн газар тогтооно”.

⁸ Нийгмийн даатгалын шимтгэл төлснөөр тооцогдох хугацаанд нийгмийн даатгалын шимтгэл төлөх журам (1994)-ын 2 дугаар зүйлийн “г”, “хууль бусаар ажлаас зайлуулагдан мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн даатгуулагчийн уг хугацаанд ногдох шимтгэлийг тухайн даатгуулагчийн хилсээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь нэг удаа нийгмийн даатгалын санд төлнө. Энэ талаар гарсан маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ”, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=201036&showType=1>.

⁹ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017)-ийн 1.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1.9 дэх заалт, “мөрдөн шалгах ажиллагаа гэж хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын явцад прокурорын зөвшөөрлөөр, эсхүл мөрдөгч бие даан явуулах энэ хуульд заасан ажиллагааг”.



- төлбөл зохих хувиар бодож ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь нийгмийн даатгалын санд төлөхөөр тодорхой заасан байна. (18)
10. Иймд нэхэмжлэгч компанийн захирлын “бусдыг хуурч мэхлэх аргаар залилсан, нотлох баримт хуурамчаар бүрдүүлсэн гэх эрүүгийн хэрэгт яллагдагчаар татаж, шалгагдсан цаг хугацаанаас 2015 оны 08 дугаар сарыг дуустал (нэхэмжлэлд заасан хугацаа) хугацааны нийгмийн даатгалын шимтгэлийг тухайн үед хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан хууль, журамд заасны дагуу даатгуулагчийн хилсээр мөрдөгдөхийн болон ял эдлэхийн өмнө авч байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дунджаас ажил олгогчийн төлбөл зохих хувиар бодож тайланг залруулж бүртгэхийг хариуцагчид даалгах нь зүйтэй. (19)
11. Харин “хөрөнгө оруулагч нарын цалинд оногдуулсан шимтгэлийг тайланд залруулж бүртгэхийг даалгах” шаардлагыг хүлээн авах үндэслэлгүй бөгөөд хөрөнгө оруулагч иргэдийн хувьд хууль бусаар мөрдөгдсөн, хилс хэргээр хорих ял эдэлсэн нөхцөл байдал байхгүй учир дээрх журмын үйлчлэлд хамаарахгүй байна. (20)
12. Дээрх үндэслэлээр нэхэмжлэлийн шаардлагаас захиралд холбогдох хэсгийг хангаж, түүнийг эрүүгийн хэрэгт яллагдагчаар татагдсан хугацаанаас 2015 оны 08 дугаар сарыг дуустал хугацааны цалинд оногдуулсан шимтгэлийн хувь хэмжээг ажил олгогчийн төлбөл зохих хувиар тухайн үед мөрдөгдөж байсан хууль, журамд заасан дүнгээр тооцож, тайланд залруулж бүртгэхийг хариуцагчид даалгаж, шийдвэр, магадлалын бусад заалтыг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн төлөөлөгчийн хяналтын журмаар гаргасан гомдлын зарим хэсгийг хангаж, үлдэх хэсгийг хэрэгсэхгүй болгон шийдвэрлэжээ.

---o0o---